МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2019 он

МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн төслийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухайхууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад тулгамдаж байгаа бэрхшээлийг шийдвэрлэх, орхигдуулсан зарим зохицуулалтыг шинээр бий болгох зэргээр өөрчлөн сайжруулах зорилгоор нийт 6 бүлэг, 12 зүйлтэйгээр боловсруулсан байх бөгөөд хуулийн төслийн бүтцийг авч үзвэл:

Нэгдүгээр бүлэг:	Нийтлэг үндэслэл
Хоёрдугаар бүлэг:	Гадаадад цагаачлах, насанд хүрээгүй иргэн зорчих, цагаачлах
Гуравдугаар бүлэг:	Гадаадад зорчих, цагаачлахад олгох баримт бичиг, хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан
Дөрөвдүгээр бүлэг:	Гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх үндэслэл, хяналт тавих
Тавдугаар бүлэг:	Гадаадад зорчсон, цагаачилсан иргэн эх орондоо буцан ирэх
Зургаадугаар бүлэг	Бусад зүйл

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу дараахь үе шаттайгаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараахь хэрэгцээ, шаардлагыг үндэслэлээ. Үүнд:

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Практикт хэрэгжих боломж
4. Харилцан уялдаа зэрэг болно.

“**Зорилгод хүрэх байдал**” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэллээ. Мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан болно.

“**Практикт хэрэгжих боломж**” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтооход туршилтын ажиллагааг явуулах цаг хугацааны боломж хомс байсан боловч хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаалчах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан мэдээлэл зэргийг ашиглах замаар үнэлэх боломжтой гэж үзэн сонголоо.

“**Хүлээн зөвшөөрөгдөх байдал**” Хуулийн төсөл эцэслэн боловсруулагдаж холбогдох этгээдүүдээс санал авах үед аргачлалд заасны дагуу уг шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн холбогдох заалтуудыг үзэх боломжтой байх тул энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

“**Ойлгомжтой байдал**” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдэд ойлгомжтой, логик дараалалтай томьёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“**Зардал**” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тусад нь тооцохоор шийдвэрлэсэн тул энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгох шаардлагагүй гэж үзэв.

“**Харилцан уялдаа**” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Үндсэн хууль холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгов. Эдгээр зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдолтой, мөн анхаарах шаардлагатай заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл, тус хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ товч бөгөөд оновчтой байх үүднээс хуулийн төслөөс шинэлэг зохицуулалт бий болгож буй, агуулгын хувьд чухал ач холбогдолтой, мөн асуудалтай, анхаарах шаардлагатай заалтуудыг сонгож, тухайн сонгосон зүйл, заалтын үр нөлөөг судаллаа. Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцохоор сонгосон хэсгээ шалгуур үзүүлэлт тус бүрээр авч үзэв.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилт, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ. Хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар:

№	**Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн төслий холбогдох заалт**	**Хуулийн төслийн зүйл, заалт**
	Монгол Улсын Үндсэн хуулийн улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй, гадаадад байхдаа төрийнхөө ивээлд байж, зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хуулийн дагуу хамгаалуулах эрхийг хангах	4.1.1.гадаадад байхдаа төрийнхөө ивээлд байж, зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хуулийн дагуу хамгаалуулах; 4.1.3.хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан төрийн үйлчилгээ авах; 4.1.4.эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах зорилгоор өөрийн биеэр, эсхүл гэр бүлийн гишүүн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газарт болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргах 4.2.2.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу гадаад улсад байнга оршин суугаа иргэн нь иргэний цахим бүртгэлд заавал бүртгүүлэх, хаягийн өөрчлөлтийг хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газарт тухай бүрт мэдээлэх; 4.2.3.гадаадад зорчихдоо Монгол Улсын эрх бүхий байгууллагаас гаргасан мэдээлэл, зөвлөмж, сэрэмжлүүлэгтэй танилцаж, тухайн улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх, аливаа гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх, гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх;

		6.3.Энэ хуулийн 6.1-д заасан этгээд улсын хилээр хамт нэвтэрсэн хүүхдийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд түүнийг асран хамгаалалтад авч үлдсэн хүний талаархи мэдээлэл, тайлбар, нотлох баримтыг Монгол Улсын хил хамгаалах байгууллагад гаргаж өгнө 8.3.Энэ хуулийн 8.1-д заасан сангийн хөрөнгийг дараахь үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна: 8.3.1.хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарил буюу чандрыг эх оронд нь авчрах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл, садангийн хүн нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах; 8.3.2.хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, терроризм, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх, эх оронд нь буцаах; 8.3.3.хилийн чанадад хорих ял эдэлж байгаад, эсхүл албадан саатуулагдаж байгаад суллагдсан иргэн эх орондоо буцах зардалгүй тохиолдолд эх оронд нь буцаах; 8.3.4.гэмт хэргийн улмаас хохирсон буюу эд хөрөнгөө хаяж гээгдүүлсний улмаас төлбөрийн чадваргүй болсон иргэнийг эх оронд нь буцаах; 8.3.5.энэ хуулийн 8.3.1-8.3.4-т заасан иргэнд үндэсний гадаад паспорт буюу буцах үнэмлэх олгох, эх оронд нь буцаахтай холбогдсон бусад үйлчилгээ үзүүлэх; 8.3.6.хилийн чанадад гэмт хэргийн улмаас хохирсон иргэнтэй холбоотой асуудлыг тухайн улсын холбогдох хууль, хяналтын байгууллагаар шалгуулах, хянуулах, эрх ашгийг нь хамгаалахад шаардагдах өмгөөлөгч, орчуулагчийг хөлслөх; 8.3.7.гадаад улсад хорих ял эдэлж байгаа иргэнийг хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газраас эргэх; 8.3.8.гадаад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээнд заасан Монголын Улсын төрийн захиргааны төв байгууллагаас гадаад улсад хүргүүлэх эрх зүйн туслалцааны хүсэлт болон холбогдох баримт бичгийг гадаад хэл рүү орчуулах төлбөрийг гаргах. 11.3.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны

		төв байгууллага нь гадаад улсын ажиллах хүчний талаар баримталж байгаа бодлого, шийдвэрийн Монгол Улсын ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөнд нөлөөлөх нөлөөллийн талаар судалгаа, дүн шинжилгээ хийж Засгийн газарт тухай бүр танилцуулна.

3.2. “Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа. /Хуулийн төсөл 6 бүлэг, 12 зүйлтэй./

3.3. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараахь зохицуулалтыг сонгон үзлээ.

№		Сонгосон зүйл, заалт
1	**Практикт хэрэгжих боломж**	4.2.2.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу гадаад улсад байнга оршин суугаа иргэн нь иргэний цахим бүртгэлд заавал бүртгүүлэх, хаягийн өөрчлөлтийг хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газарт тухай бүрт мэдээлэх;
2		6.3.Энэ хуулийн 6.1-д заасан этгээд улсын хилээр хамт нэвтэрсэн хүүхдийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд түүнийг асран хамгаалалтад авч үлдсэн хүний талаархи мэдээлэл, тайлбар, нотлох баримтыг Монгол Улсын хил хамгаалах байгууллагад гаргаж өгнө. 6.4.Энэ хуулийн 6.3-т заасан байгууллага нь насанд хүрээгүй хүнийг үлдээсэн шалтгааныг нь тодруулж, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлыг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлнэ.
3		9.4.Хилийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн Монгол Улсын иргэдийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтөлнө.

3.4. “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог тогтоохын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо. /Хуулийн төсөл 6 бүлэг, 12 зүйлтэй./

ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараахь байдлаар харуулав.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл

1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 4.1.1-4.1.4, 4.2.2, 4.3.3, 6.3.2,6.3.3, 8.3, 11.2, 11.3	Зорилгод дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 4.2.2, 6.3,6.4, 9.4. дэх хэсэг	Практикт тухайн төрлийн харилцаанд гарч болох хүндрэлийг судлах.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах.

4.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй, гадаадад байхдаа төрийнхөө ивээлд байж, зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хуулийн дагуу хамгаалуулах эрхийг хангах зорилготой байна. Эдгээр зорилго нь хуулийн төслөөс сонгож авсан дараахь зохицуулалтаар хангагдаж байна гэж үзлээ.

4.1.1.гадаадад байхдаа төрийнхөө ивээлд байж, зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хуулийн дагуу хамгаалуулах; 4.1.3.хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан төрийн үйлчилгээ авах;

Гадаадад түр болон удаан хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэн нь оршин суугаа газраасаа үл хамааран Монгол Улсын төрийн хамгаалалтад байх агуулгыг энэхүү заалтаар тусган зохицуулсан байна. Энэ нь хуулийн төслийн зорилгод чиглэгдсэн зохицуулалт болно.

Гэхдээ иргэн өөрөө хариуцлагатай байх, өөрөөс хамаарсан үйл ажиллагааг хуульд заасны дагуу хэрэгжүүлсэн байхыг шаардах нь зүй ёсны асуудал юм. Энэ нь дараахь заалтаар дамжин хэрэгжиж байж хуулийн зорилгод хүрнэ гэж үзэж байна.

4.2.2.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу гадаад улсад байнга оршин суугаа иргэн нь иргэний цахим бүртгэлд заавал бүртгүүлэх, хаягийн өөрчлөлтийг хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газарт тухай бүрт мэдээлэх;
4.2.3.гадаадад зорчихдоо Монгол Улсын эрх бүхий байгууллагаас гаргасан мэдээлэл, зөвлөмж, сэрэмжлүүлэгтэй танилцаж, тухайн улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх, аливаа гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх, гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх;
6.3.Энэ хуулийн 6.1-д заасан этгээд улсын хилээр хамт нэвтэрсэн хүүхдийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд түүнийг асран хамгаалалтад авч үлдсэн хүний талаархи мэдээлэл, тайлбар, нотлох баримтыг Монгол Улсын хил хамгаалах байгууллагад гаргаж өгнө

Ийнхүү бүртгэлд хамрагдсан иргэд нь энэ хуулийн төсөл болон бусад хууль тогтоомжийн дагуу төрийн ивээлдээ багтаж, эрх ашиг сонирхолоо хамгаалуулах боломжийг бүрдүүлж байж хуулийн зорилгод хүрэх юм.

8.3.Энэ хуулийн 8.1-д заасан сангийн хөрөнгийг дараахь үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна: 8.3.1.хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарил буюу чандрыг эх оронд нь авчрах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл, садангийн хүн нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах; 8.3.2.хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, терроризм, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх, эх оронд нь буцаах; 8.3.3.хилийн чанадад хорих ял эдэлж байгаад, эсхүл албадан саатуулагдаж байгаад суллагдсан иргэн эх орондоо буцах зардалгүй тохиолдолд эх оронд нь буцаах; 8.3.4.гэмт хэргийн улмаас хохирсон буюу эд хөрөнгөө хаяж гээгдүүлсний улмаас төлбөрийн чадваргүй болсон иргэнийг эх оронд нь буцаах; 8.3.5.энэ хуулийн 8.3.1-8.3.4-т заасан иргэнд үндэсний гадаад паспорт буюу буцах үнэмлэх олгох, эх оронд нь буцаахтай холбогдсон бусад үйлчилгээ үзүүлэх; 8.3.6.хилийн чанадад гэмт хэргийн улмаас хохирсон иргэнтэй холбоотой асуудлыг тухайн улсын холбогдох хууль, хяналтын байгууллагаар шалгуулах, хянуулах, эрх ашгийг нь хамгаалахад шаардагдах өмгөөлөгч, орчуулагчийг хөлслөх; 8.3.7гадаад улсад хорих ял эдэлж байгаа иргэнийг хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газраас эргэх; 8.3.8.гадаад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээнд заасан Монголын Улсын төрийн захиргааны төв байгууллагаас гадаад улсад хүргүүлэх эрх зүйн туслалцааны хүсэлт болон холбогдох баримт бичгийг гадаад хэл рүү орчуулах төлбөрийг гаргах.

Дээрх зохицуулалт нь гадаадад байхдаа төрийнхөө ивээлд байж, зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хуулийн дагуу хамгаалуулах эрхийг хангах зорилготой зорилгод чиглэгдсэн зохицуулалт байна. Уг зохицуулалтаар зорилгод хүрэх боломжтой байна гэж үзлээ.

	11.3.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гадаад улсын ажиллах хүчний талаар баримталж байгаа бодлого, шийдвэрийн Монгол Улсын ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөнд нөлөөлөх нөлөөллийн талаар судалгаа, дүн шинжилгээ хийж Засгийн газарт тухай бүр танилцуулна.

Энэ нь монгол Улсын иргэн хэдийгээр гадаад улсад чөлөөтэй зорчих эрхтэй гэсэн гадаадад зорчихоос өмнө иргэдийг бодит, баталгаажсан мэдээллээр хангах, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, ажиллах хүчний нөөц бололцоонд тулгуурлан Монгол Улсын Засгийн газраас оновчтой бодлого шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой зохицуулалт байна.

4.2. **“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хуулийн төслийн эдгээр зохицуулалт нь тэдгээрийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэхэд боломжтой байдлаар тусгасан эсэх, зохицуулалтыг хэрэгжүүлэх байгууллагад хэрэгжүүлэх боломж, нөөц байгаа эсэхийг судлахаар зорьсон. Үнэлгээний энэ хэсгийг практикт туршилт явуулах замаар хийдэг боловч үнэлгээний онцлогоос хамааран санал авах, одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх замаар шийдвэрлэх боломжтой гэж үзсэн болно.

№	Сонгосон зүйл, заалт
1	4.2.2.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу гадаад улсад байнга оршин суугаа иргэн нь иргэний цахим бүртгэлд заавал бүртгүүлэх, хаягийн өөрчлөлтийг хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газарт тухай бүрт мэдээлэх;

Энэхүү заалт нь тус хуулийн төсөлд тусгагдсан Монгол Улсын иргэнийг төр нь хамгаалах, төрийн бүхий л үйлчилгээг хүртээмжтэй үзүүлэх зорилгоор тусгасан. Энэ нь практикт иргэдийн өөрийн санаачлагад тулгуурласан хэрэгжиж байсан. Харин хуулийн төсөлд цахим хэлбэрээр бүртгүүлэх боломжийг тусгасан нь хэрэгжих боломжийг нэмэгдүүлсэн зохицуулалт болсон байна. Учир нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Үндэсний статистикийн газрын хамтарсан 2017 оны А/24, А/157, А/93. дугаар тушаалаар гадаадад шилжих хөдөлгөөний статистик мэдээллийг сайжруулах төсөл боловсруулан ажилласан. Төслийн хүрээнд гадаадад оршин суугаар иргэдийг цахим хэлбэрээр бүртгэх программ боловсруулан ажиллуулж байна. Тус программ нь иргэд интернэтээр холбогдон бүртгүүлэх тул тухайн улсад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газар хол, ойр байгаагаар хамаарахгүйгээр, түүнчлэн оршин суугаа улсад дипломат төлөөлөгчийн газар байдагггүй улсаас ч холбогдон бүртгүүлэх давуу талтай байна. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдийн бүртгэл мэдээллийг бий болгож тогтмолжуулсанаар тэдгээрийг эрх ашиг сонирхлыг хамгаалах, хуульд заасан төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ач холбогдолтой байна.

№	Сонгосон зүйл, заалт
1	6.3.Энэ хуулийн 6.1-д заасан этгээд улсын хилээр хамт нэвтэрсэн хүүхдийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд түүнийг асран хамгаалалтад авч үлдсэн хүний талаархи мэдээлэл, тайлбар, нотлох баримтыг Монгол Улсын хил хамгаалах байгууллагад гаргаж өгнө. 6.4.Энэ хуулийн 6.3-т заасан байгууллага нь насанд хүрээгүй хүнийг үлдээсэн шалтгааныг нь тодруулж, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлыг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлнэ.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулиар дээрх зохицуулалтууд тусгагдаж хэрэгжиж байгаа. Харин насанд хүрээгүй хүүхдийг үлдээсэн шалтгааныг тодруулахаар цагдаагийн байгууллагад шилжүүлж болно гэж тусган хэрэгжиж байсан заалтыг шилжүүлнэ гэж үүрэг болгон тусгасан байна. Иймд тус заалт практикт хэрэгжиж тогтсон байна.

4.3. “Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгасан бөгөөд үүнд хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн зохицуулалттай нийцэж байгаа, давхардаж байгаа эсэхийг “харилцан уялдаа холбоо” шалгуур үзүүлэлтийн хүрээнд шалгасан болно.

Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг сайжруулахад чиглэсэн санал дүгнэлт

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1	3.1.3.”үндэсний гадаад паспорт түүнийг орлох бичиг баримт” гэж Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 17.1-д заасан баримт бичгийг.	Хуулийн төсөлд нэр томьео хэрэглэсэн боловч хуулийн төсөлд үндэсний гадаад пасдортын талаар тусгагдсан заалтууд байх боловч түүнийг орлох баримт бичгийн талаар тусгагдсан заалт байхгүй байна	Үндэсний гадаад паспорт, түүнийг орлох бичиг баримтын талаарх заалт байх шаардлагатай эсэхийг нягтлах
	7.5.Хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газар нь үндэсний гадаад паспорт олгохдоо тухайн иргэний талаар иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас холбогдох лавлагаа авах ба олгосон гадаад паспортын талаархи мэдээллийг тухай бүр хүргүүлнэ.	Энэ талаарх мэдээллийг ямар хугацаанд ирүүлж байх нь тодорхойгүй байна.	Тухай бүр гэсэн хугацааг тодорхой тусгах Эсхүл хууль тогтоомжид заасан хугацаанд гэж тусгах. Энэ нь Засгийн газрын тогтоолоор эрх шилжүүлсэн заалтаар хэрэгжих журамд тусгах агуулгыг оруулах
3	4.2.2.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу гадаад улсад байнга оршин суугаа иргэн нь иргэний цахим бүртгэлд заавал бүртгүүлэх, хаягийн өөрчлөлтийг хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газарт тухай бүрт мэдээлэх;	Бүртгүүлэх хугацааг тодорхой болгох тухайлал жил бүр эсхүл хагас жил тутам уу гэдэг нь тодорхойгүй байна. Түүнчлэн хаягийн өөрчлөлтийг мөн цахимаар уу гэдгийг тодорхой болгох	Бүртгүүлэх давтамжийг тодорхой тусгах

4.4. “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд

№	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Нийцэж байна.

2	Хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Хуулийн төслийн 2.1-д заасан хуулиуд нь Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн төслөөр зохицуулах харилцаанд хамаарах хуулиуд байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	“Гадаадад”, “Хилийн чанадад” гэж 2 өөр бичигдсэнийг анхаарч, аль нэгийг хэрэглэх
4	Хуулийн төслийн зүйл, заалт төслийн бусад заалттай нийцэж байгаа эсэх	Нийцэж байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт бусад хуулийн заалттай нийцсэн эсэх	Нийцэж байна.
6	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Давхардаагүй
7	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төсөлд уг хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан.
8	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Шаардлагатай асуудлуудыг тусгасан
9	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төслөөр төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан зохицуулалт байхгүй.
10	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой чиг үүрэг байхгүй.
11	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Татвар хураамж тогтоосон хэсэг байхгүй.
12	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт байхгүй.
13	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Зохицуулалт туссан. Монгол Улсын иргэний гадаадад зорчих, цагаачлах эрхийг хязгаарлах үндэслэлтийг энэ хуулийн төслөөр тусгасан. Энэ нь Монгол Улсын ҮНдсэн хуулийн . Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно. Гэсэн заалтын дагуу тусгасан зохицуулалт байна.
14	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
15	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
16	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
17	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Хуулийн төсөлд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар тусгасан.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үнэлгээний ажлын явцад хуулийн төслийн харилцан уялдаа, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийг батлан хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй, урьдчилан тооцоогүй үр дагаврыг тодорхойлох зорилгын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, гадаадын улс орны хууль тогтоомж, уг асуудлын хүрээнд хийгдсэн албан ёсны судалгааг ашиглан дүн шинжилгээ хийх замаар хийж гүйцэтгэлээ.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу иргэн улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй, гадаадад байхдаа төрийнхөө ивээлд байж, зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хуулийн дагуу хамгаалуулах эрхийг хангах зорилготой байна. Хуулийн төслийн заалтууд нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэгдсэн байна. Ялангуяа гадаад оршин суугаа иргэд нь дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан төрийн үйлчилгээг авах, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу Хилийн чанадад байгаа иргэдэд туслах сангийн хөрөнгөөр гүйцэтгэх үйл ажиллагаа буюу иргэдэд туслах үйл ажиллагааны хэлбэрийг Засгийн газрын тогтоолоор зохицуулж байсныг хуулийн төсөлд тусгасан нь уг үйл ажиллагааны хэрэгжих боломжийг нэмэгдүүлсэн, тусламж шаардлагатай иргэдэд ойлгомжтой, тодорхой болсон байна гэж үзлээ.

Нэг талаас Монгол Улсын төрийн ивээлд багтан, эрх ашиг, сонирхлоо хамгаалуулах иргэдийн эрх, нөгөө талаас гадаадад байгаа иргэд өөрсдөө гадаадад оршин суух хугацаандаа тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газраа хаягийн бүргэлийг заавал хийлгэж байх үүрэг, гадаадад байхдаа хариуцлагатай байх, гэмт хэрэг зөрчилд холбогдохгүй байх, хохирогч болохоос урьдчилан сэргийлэх зэрэг тодорхой үүрэг хүлээлгэсэн зохицуулалтуудыг тусгасан нь хуулийн төслийн зорилгыг дэмжсэн уялдаа холбоо бүхий зохицуулалт болсон байна.

Энэхүү заалт нь тус хуулийн төсөлд тусгагдсан Монгол Улсын иргэнийг төр нь хамгаалах, төрийн бүхий л үйлчилгээг хүртээмжтэй үзүүлэх зорилгоор тусгасан. Энэ нь практикт иргэдийн өөрийн санаачлагад тулгуурласан хэрэгжиж байсан. Харин хуулийн төсөлд цахим хэлбэрээр бүртгүүлэх боломжийг тусгасан нь хэрэгжих боломжийг нэмэгдүүлсэн зохицуулалт болсон байна. Учир нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Үндэсний статистикийн газрын хамтарсан 2017 оны А/24, А/157, А/93. дугаар тушаалаар гадаадад шилжих хөдөлгөөний статистик мэдээллийг сайжруулах төсөл боловсруулан ажилласан. Төслийн хүрээнд гадаадад оршин суугаар иргэдийг цахим хэлбэрээр бүртгэх программ боловсруулан ажиллуулж байна. Тус программ нь иргэд интернэтээр холбогдон бүртгүүлэх тул тухайн улсад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газар хол, ойр байгаагаар хамаарахгүйгээр, түүнчлэн оршин суугаа улсад дипломат төлөөлөгчийн газар байдагггүй улсаас ч холбогдон бүртгүүлэх давуу талтай байна. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдийн бүртгэл мэдээллийг бий болгож тогтмолжуулсанаар тэдгээрийг эрх ашиг сонирхлыг хамгаалах, хуульд заасан төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ач холбогдолтой байна.

Хуулийн төсөлд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн байгууллагууд болох Засгийн газар болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн, хууль зүй, дотоод хэргийн ауудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн, хилийн асуудал эрхэлсэн, цагдаагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудын хэрэгжүүлэх үүргийн талаар тодорхой заалтууд тусгасан байна.

Эдгээр нь огт байгаагүй зохицуулалт биш хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд тусгагдсан, хэрэгжиж хэвшсэн зохицуулалтууд бөгөөд гагцхүү хуулийн төслөөр чиг үүргийг тодорхой болгосон, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ойлгомжтой болгон тусгасан байна. Ийнхүү асуудлыг илүү тодорхой тусгасан нь практикт хэрэгжих боломжийг нэмэгдүүлсэн байна.

Харин зарим асуудлыг хуульд тусгаснаас илүү нарийн тодорхой болгох нь зүйтэй байна. Тухайлбал: хуулийн төслийн 4.4.2-т заасны дагуу гадаад оршин суугаа иргэд Дипломат төлөөлөгчийн газар заавал бүртгүүлэх үүргийг тусгасан боловч ямар хугацаанд бүртгүүлэх, ямар давтамжтайгаар бүртгүүлэхийг тодорхой тусгах /жил бүр гэх мэтчлэн/.

Түүнчлэн хуулийн төслийн 7.5-д “Хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газар нь үндэсний гадаад паспорт олгохдоо тухайн иргэний талаар иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас холбогдох лавлагаа авах ба олгосон гадаад паспортын талаархи мэдээллийг тухай бүр хүргүүлнэ.” гэж тусгасан. Энэхүү заалтын тухай бүр гэсэн хугацааг тодорхой тусгах, эсхүл хууль тогтоомжид заасан хугацаанд гэж тусгах нь зүйтэй.

---o0o---